



БУЛГАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Боловсрол Шинжлэх ухааны газрын 2022 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: БУА-2023/183/-НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:

www.audit.mn

Булган аймаг

2023 он

Аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: Б.Эрдэнэ
Утас:70342580 Цахим хаяг: Erdene.B@audit.local
Аудитын менежер: Ж.Энхцоодол
Утас: 70342716 Цахим хаяг: Enkhtsoodolj@audit.gov.mn
Аудитор: З.Ганбаатар
Утас: 70342716 Цахим хаяг: ganbaatarz@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. Хараат бус аудиторын дүгнэлт
 2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл
 3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....
 - 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа.....
 - 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин
 - 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....
 - 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт
 4. Аудитын тайлан
 - 4.1 Ерөнхий зүйл
 - 4.2 Материаллаг байдал
 - 4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт.....
 - 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал
 - 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
 - 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал
5. Аудитын илрүүлэлт
 6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт

АДБОУС Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт

ТӨБЗГ Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан



**БУЛГАН АЙМГИЙН
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Анхдагчдын өргөн чөлөө 1-120,
Жаргалант баг, Булган сум, Булган аймаг, 63082
Утас/Факс: 7034-2580
E-mail: bulgan@audit.gov.mn

2023.09.24 № 157
танай _____ ны № _____ т

АЙМГИЙН БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ
УХААНЫ ГАЗРЫН ДАРГА
Ж.ГАНБОЛД ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу аймгийн Боловсрол, шинжлэх ухааны газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Аймгийн Боловсрол, шинжлэх ухааны газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Швейцарын хөгжлийн агентлаг, БОАЖЯ, БШУЯ-ны санаачлага, БОМСТ-ийн гүйцэтгээр хэрэгжүүлж буй тогтвортой хөгжлийн боловсрол-2 төслийн хүрээнд Хангал сумын Хялганат тосгоны ЕБС-ийн дэргэдэх "Эко кемп-зуны сургалтын төв" байгуулан төслөөс 22.5 сая төгрөг, орон нутгийн санхүүжилтээр 7.5 сая төгрөгөөр санхүүжилт хийгдэн байгуулан ажиллаж байна.

Хоол, сургалтын заал, гадаах амрах талбай зэрэгт аймгийн хөрөнгө оруулалтаас 20 сая төгрөг, сумын олон нийт иргэдийн тусламж, дэмжлэгээр бүтээн байгуулалт хийгдэж байна.

Тус эко кемп-зуны сургалтын төв нь төслөөс 22.5 сая, орон нутгаас 27.5 сая төгрөгөөр хэрэгжиж байна. Тус кемп нь хөвгүүд охидын 6 байр нийт 30 хүүхэд хүлээн авах чадалтай ба 2022 онд нээлтээ хийж 90 гаруй сурагчдыг хүлээж авч тогтвортой хөгжлийн үзэл баримтлалыг тусгасан сургалт, үйл ажиллагааг зохион байгуулан ажилласан. Тухайн ажлын хүрээнд туршилтын талбайд хус, улиас, нарс, монос, шар хуиалс, шинс төрлийн 10,000.0 орчим модыг үрээр болон суулгацаар тариалан энэ онд аймгийн ЕБС-ийн 8 сургууль, 8 цэцэрлэгт 4000 гаруй модны суулгацыг өгч, хамтран тариалсан байна.

006020193

Аудитын гол асуудал

2022 оны жилийн эцсийн байдлаар Бодлогын баримт бичигт тусгагдсан 4 зорилт, 41 арга хэмжээний хэрэгжилт хүрээнд 1-р зорилт арга хэмжээ 78.3, 2-р зорилт арга хэмжээ 98.8, 3-р зорилт арга хэмжээ 90.0, 4-р зорилт арга хэмжээ 95.5-ийн гүйцэтгэлтэйгээр аймгийн Засаг даргатай байгуулсан хамтран ажиллах гэрээгээр хүлээсэн үүргийн хэрэгжилт 90,7 хувьтай байна.

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 3 хөтөлбөрийн 3 арга хэмжээг санхүүжүүлэхээр 3,343,512.5 мянган төгрөгийг улсын төсвөөс авсан байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс төгрөгийн санхүүжилт авч 3,363,718.5 мянган төгрөгийг зарцуулж үлдэгдэл 72,801.6 сая төгрөгийн улсын төсөвт төвлөрүүлсэн.

Булган аймгийн Засаг даргын 2022.01.31-ний өдрийн А/63 захирамжаар 13,000.0 төгрөг, 2021.12.31-ний өдрийн А/604 захирамжаар 17,162.8 төгрөг, 2022.04.19 өдрийн А/247ийн захирамж 40,421.6 төгрөг, Тоглонгоо суралцъя А/106 гэрээний төлбөр 23,092.0 төгрөг, Боловсролын ерөнхий газрын даргын А/342, А/353, А/366, А/308, А/192, 60,802.0 төгрөг, Боловсролын үнэлгээний төвийн А/88 тушаалаар 2,277,0 төгрөг, тус бүр зориулалтын дагуу зарцуулж бүрэн зарцуулсан байна.

Аймгийн Боловсрол, шинжлэх ухааны газрын 2022 оны санхүүгийн тайлангийн аудитад нөлөөлөх гол асуудал илрээгүй байна.

Бусад асуудлын хэсэг

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.ЭРДЭНЭ

САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>70,659,074.25</u>	<u>71,987,778.25</u>
35	БАРАА МАТЕРИАЛ	70,659,074.25	71,987,778.25
351	Түүхий эд материал	26,730,850.00	16,259,209.00
35110	Тусгай зориулалттай материал	26,730,850.00	16,259,209.00
354	Хангамжийн материал	43,928,224.25	55,728,569.25
35410	Бичиг хэргийн материал	384,000.00	384,000.00
35420	Аж ахуйн материал	42,283,024.25	54,083,369.25
35430	Сэлбэг хэрэгсэл	75,000.00	75,000.00
35450	Барилгын засварын материал	1,186,200.00	1,186,200.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>504,795,573.02</u>	<u>506,813,405.12</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	504,795,573.02	506,813,405.12
392	Биет хөрөнгө	427,839,573.02	429,857,405.12
39201	Барилга, байгууламж, орон сууц	389,876,569.00	389,876,569.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(76,746,622.52)	(88,918,930.28)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	74,155,269.00	52,655,269.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(33,171,756.36)	(21,383,512.72)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	215,848,210.40	239,112,264.40
39206	Хуримтлагдсан элэгдэл	(152,636,266.48)	(154,076,948.82)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	36,855,404.00	36,887,200.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(29,393,694.38)	(27,346,965.82)

39209	Зам, гүүрийн байгууламж	621,900.00	621,900.00
39210	Хуримтлагдсан элэгдэл	(422,400.00)	(422,400.00)
39214	Бусад үндсэн хөрөнгө	2,852,960.36	2,852,960.36
393	Биет бус хөрөнгө	76,956,000.00	76,956,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	76,956,000.00	76,956,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>575,454,647.27</u>	<u>578,801,183.37</u>
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>574,876,177.27</u>	<u>578,801,183.37</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	574,876,177.27	578,801,183.37
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	553,048,860.02	553,048,860.02
51101	Өмч: - төрийн	553,048,860.02	553,048,860.02
512	Хуримтлагдсан үр дүн	(117,119,137.91)	(113,194,131.81)
51210	Өмнөх үеийн үр дүн	(127,556,067.57)	(117,119,137.91)
51220	Тайлант үеийн үр дүн	10,436,929.66	3,925,006.10
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	138,946,455.16	138,946,455.16
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>575,454,647.27</u>	<u>578,801,183.37</u>

СТ-2А

САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,717,488,062.21	3,668,781,405.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	72,213,885.21	119,263,530.00
120	Нийтлэг татварын бус орлого	72,213,885.21	119,263,530.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	72,213,885.21	119,263,530.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	72,213,885.21	117,703,530.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,645,274,177.00	3,549,517,875.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,497,840,300.00	3,362,158,500.00

131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,497,840,300.00	3,362,158,500.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	147,433,877.00	187,359,375.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	17,490,000.00	95,955,100.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	49,171,177.00	82,344,275.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,712,181,431.35	3,664,856,398.90
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,712,181,431.35	3,664,856,398.90
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	557,301,656.50	749,172,157.57
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	243,692,904.33	301,320,373.91
210101	Үндсэн цалин	184,691,994.32	201,353,225.37
210102	Нэмэгдэл	43,068,058.33	42,676,206.88
210103	Унаа хоолны хөнгөлөлт	10,137,363.68	35,741,982.67
210104	Урамшуулал	5,795,488.00	21,548,958.99
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	31,754,422.82	37,812,366.26
210201	Тэтгэврийн даатгал	21,990,562.21	25,813,562.97
210202	Тэтгэмжийн даатгал	2,444,389.61	2,999,700.85
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,955,511.64	2,399,760.63
210204	Ажилгүйдлийн даатгал	475,180.06	599,940.15
210205	Эрүүл мэндийн даатгал	4,888,779.30	5,999,401.66
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	39,428,441.00	59,770,167.00
210301	Гэрэл, цахилгаан	2,180,471.00	3,206,914.00
210302	Түлш, халаалт	33,435,600.00	52,364,633.00
210303	Цэвэр, бохир ус	3,812,370.00	4,198,620.00
2104	Хангамж, бараа материалын зардал	73,969,743.96	137,232,613.00
210401	Бичиг хэрэг	7,609,247.00	5,893,900.00
210402	Тээвэр, шатахуун	3,836,000.00	9,015,475.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	366,280.00	416,200.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	12,508,000.00	556,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	567,000.00	123,100.00
210409	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн /ТӨҮГ/	49,055,466.96	107,070,642.00

2107	Томилолт, зочны зардал	272,700.00	114,500.00
210702	Дотоод албан томилолт	272,700.00	114,500.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	90,704,047.00	17,901,681.50
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	90,704,047.00	17,901,681.50
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	77,479,397.39	194,420,455.90
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	487,050.00	7,055,340.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	29,396,140.00	139,410,060.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	47,596,207.39	47,955,055.90
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,154,879,774.85	2,915,684,241.33
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,146,491,900.00	2,843,118,943.32
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	549,213,400.00	1,384,696,175.32
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	596,950,500.00	1,458,094,768.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	328,000.00	328,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	8,387,874.85	72,565,298.01
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	8,387,874.85	72,565,298.01
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>5,306,630.86</u>	<u>3,925,006.10</u>
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>5,306,630.86</u>	<u>3,925,006.10</u>

СТ-2А

МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>1,645,274,177.00</u>	<u>3,551,077,875.00</u>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	0.00	1,560,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	0.00	1,560,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	0.00	1,560,000.00

1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	0.00	1,560,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1645274177.00	3,549,517,875.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,497,840,300.00	3,362,158,500.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,497,840,300.00	3,362,158,500.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	147,433,877.00	187,359,375.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	17,490,000.00	95,955,100.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	49,171,177.00	82,344,275.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	0.00	9,060,000.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>1,616,748,277.00</u>	<u>3,511,737,875.00</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,616,748,277.00	3,511,737,875.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	461,868,502.15	596,053,633.67
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	233,574,027.15	301,320,373.91
210101	Үндсэн цалин	174,825,898.17	201,353,225.37
210102	Нэмэгдэл	41,792,679.65	42,676,206.88
210103	Унаа хоолны хөнгөлөлт	10,137,363.68	35,741,982.67
210104	Урамшуулал	6,818,085.65	21,548,958.99
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	31,673,300.00	37,812,366.26
210201	Тэтгэврийн даатгал	23,108,700.00	25,813,562.97
210202	Тэтгэмжийн даатгал	2,141,200.00	2,999,700.85
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,712,900.00	2,399,760.63
210204	Ажилгүйдлийн даатгал	428,200.00	599,940.15
210205	Эрүүл мэндийн даатгал	4,282,300.00	5,999,401.66
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	38,849,971.00	60,348,637.00
210301	Гэрэл, цахилгаан	2,180,471.00	3,206,914.00
210302	Түлш, халаалт	31,077,500.00	52,943,103.00
210303	Цэвэр, бохир ус	5,592,000.00	4,198,620.00

2104	Хангамж, бараа материалын зардал	23,804,007.00	19,823,900.00
210401	Бичиг хэрэг	6,334,627.00	4,537,300.00
210402	Тээвэр, шатахуун	3,834,800.00	5,183,600.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	366,280.00	416,200.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	12,763,200.00	1,086,800.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	316,100.00	8,600,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	0.00	9,389,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	0.00	999,000.00
210604	Урсгал засвар	0.00	8,390,000.00
2107	Томилолт, зочны зардал	272,700.00	114,500.00
210702	Дотоод албан томилолт	272,700.00	114,500.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	101,139,357.00	15,618,881.50
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	101,139,357.00	15,618,881.50
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	32,555,140.00	151,625,975.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	237,000.00	9,295,400.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	32,318,140.00	142,330,575.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,154,879,774.85	2,915,684,241.33
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,146,491,900.00	2,843,118,943.32
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	549,213,400.00	1,384,696,175.32
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	596,950,500.00	1,458,094,768.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	328,000.00	328,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	8,387,874.85	72,565,298.01
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	83,87,874.85	72,565,298.01
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>28,525,900.00</u>	<u>39,340,000.00</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	28,525,900.00	39,340,000.00

22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	28,525,900.00	39,340,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	28,525,900.00	39,340,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	0.00	39,340,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>-28,525,900.00</u>	<u>-39,340,000.00</u>

СТ-4А

ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2016 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	553,048,860.02	138,946,455.16	-127,556,067.57	564,439,247.61
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	553,048,860.02	138,946,455.16	-127,556,067.57	564,439,247.61
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	0.00	0.00	0.00	0.00
C07	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	10,436,929.66	10,436,929.66
C08	2016 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	553,048,860.02	138,946,455.16	-117,119,137.91	574,876,177.27
D01	2017 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	553,048,860.02	138,946,455.16	-117,119,137.91	574,876,177.27
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	553,048,860.02	138,946,455.16	-117,119,137.91	574,876,177.27
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	0.00	0.00	0.00	0.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	0.00	0.00	0.00	0.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00	0.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү				0.00
D08	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	3,925,006.10	3,925,006.10
D09	2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	553,048,860.02	138,946,455.16	-113,194,131.81	578,801,183.37

ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	3,343,512,500.00	3,291,153,201.99
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,343,512,500.00	3,291,153,201.99
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	514,541,200.00	448,034,258.67
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	357,113,300.00	301,320,373.91
210101	Үндсэн цалин	218,035,300.00	201,353,225.37
210102	Нэмэгдэл	71,422,700.00	42,676,206.88
210103	Унаа хоолны хөнгөлөлт	31,944,000.00	35,741,982.67
210104	Урамшуулал	35,711,300.00	21,548,958.99
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	44,636,600.00	37,812,366.26
210201	Тэтгэврийн даатгал	30,354,600.00	25,813,562.97
210202	Тэтгэмжийн даатгал	3,571,100.00	2,999,700.85
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,856,900.00	2,399,760.63
210204	Ажилгүйдлийн даатгал	713,700.00	599,940.15
210205	Эрүүл мэндийн даатгал	7,140,300.00	5,999,401.66
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	32,976,900.00	59,498,637.00
210301	Гэрэл, цахилгаан	2,159,200.00	2,356,914.00
210302	Түлш, халаалт	26,118,000.00	52,943,103.00
210303	Цэвэр, бохир ус	4,699,700.00	4,198,620.00
2104	Хангамж, бараа материалын зардал	9,133,000.00	8,364,400.00
210401	Бичиг хэрэг	2,471,300.00	2,260,300.00
210402	Тээвэр, шатахуун	3,188,000.00	2,983,600.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	444,800.00	416,200.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	949,700.00	883,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,920,400.00	1,821,300.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	-	9,999,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	-	9,999,000.00
2107	Томилолт, зочны зардал	114,500.00	114,500.00
210702	Дотоод албан томилолт	114,500.00	114,500.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	52,301,200.00	10,801,381.50
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	52,301,200.00	10,801,381.50
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	18,265,700.00	20,123,600.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	9,962,100.00	9,295,400.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	8,303,600.00	10,828,200.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,828,971,300.00	2,843,118,943.32

2132	Бусад урсгал шилжүүлэг	2,828,971,300.00	2,843,118,943.32
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	1,366,333,900.00	1,384,696,175.32
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	1,462,309,400.00	1,458,094,768.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	328,000.00	328,000.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	3,341,955,500.00	3,362,158,500.00
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	3,341,955,500.00	3,362,158,500.00
131001	Улсын төсвөөс санхүүжих	3,341,955,500.00	3,362,158,500.00
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	-	1.00
610001	Төсвийн байгууллага	-	1.00
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	-	22.00
620001	Удирдах ажилтан	-	1.00
620002	Гүйцэтгэх ажилтан	-	15.00
620003	Үйлчлэх ажилтан	-	6.00
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	-	22.00
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)		16.00
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)		6.00

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

2022 оны жилийн эцсийн байдлаар Бодлогын баримт бичигт тусгагдсан 4 зорилт, 41 арга хэмжээний хэрэгжилт хүрээнд 1-р зорилт арга хэмжээ 78,3%, 2-р зорилт арга хэмжээ 98,8%, 3-р зорилт арга хэмжээ 90%, 4-р зорилт арга хэмжээ 95,5%-ийн гүйцэтгэлтэйгээр аймгийн Засаг даргатай байгуулсан хамтран ажиллах гэрээгээр хүлээсэн үүргийн хэрэгжилт 90,7 хувьтай байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

МУ-ын ЗГ-ын 91-р тогтоол .БШУ-ны сайдын 170-р тушаал ,бусад боловсролын шинэчлэлтэй холбогдон гарсан хууль эрх зүйн актуудын мөрдлөг болгон ажилласан.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй, НБББББ-ийг 2021 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн А/179 дугаар тушаалаар шинэчлэн баталсан байна.

Дотоод аудит/аудиторын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах /дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Боловсрол Шинжлэх ухааны газар 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал/мөнгөн сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллага нь НБББББ-аа БСШУС-ын сайдын 2017 оны 2 дугаар сарын 7-ны өдрийн А/40 тоот тушаалаар баталсан баримт бичгийг мөрдөн ажилласан байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Боловсрол Шинжлэх ухааны газар 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 1.5 сая төгрөгөөр буюу 1.2 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0	0	0
Авлага	0	0	0
Бараа материал	70,659.1	71,987.7	1,328.6
Үндсэн хөрөнгө	797,916.3	798,962.1	1,045.8
Нийт хөрөнгө	868,575.4	870,949.8	2,374.4
Өр төлбөр	0	0	0
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	574,876.1	578,801.1	3,925.0
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	575,454.6	578,801.1	3,346.5

Дээрх хүснэгтээс харахад бараа материал өмнөх оны үзүүлэлтээс 1,328.6 өсөж, үндсэн хөрөнгө 1,045.8 мянган төгрөгөөр нэмэгджээ. Энэ нь тайлант онд үндсэн хөрөнгийн дансанд төсвийн хөрөнгөөр худалдан авсан 39,340.0, үнэ төлбөргүй шилжүүлэн авсан 10,632.8 мянган төгрөгийн хөрөнгө тус тус нэмэгдсэн байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлж ажилласан.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 3,343,512.5 мянган төгрөгөөр нийт зарлагыг 3,363,718.5 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн.

Төсвийн төслийн саналыг төслийн хүргүүлсэн дүнгээр баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 3 хөтөлбөрийн 3 арга хэмжээг санхүүжүүлэхээр 3,343,512.5 мянган төгрөгийг баталсан байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 3,362,158.5 төгрөгийн санхүүжилт авч 3,363,718.5 мянган төгрөгийг зарцуулж үлдэгдэл 72,565.3 мянган төгрөгийн улсын төсөвт төвлөрүүлсэн.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/Мянган төгрөгөөр/

Д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	71808 /80802/ ажил олгогчоос тэтгэмж, урамшуулал, дэмжлэг	47,936.9	47,835.6	101.2	99.7
2	71808 /80101/ үндсэн үйл ажиллагаа	487,138.0	448,034.2	39,104.0	94.6
3	71801 СӨБ /80802 /	416,498.6	401,462.3	15,036.2	96.4
4	71802 ЕБС /80802/	2,412,144.7	2,393,820.8	18,323.8	99.2

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Булган аймгийн Засаг даргын 2022.01.31-ний өдрийн А/63 захирамжаар 13,000.0 төгрөг, 2021.12.31-ний өдрийн А/604 захирамжаар 17,162.8 төгрөг, 2022.04.19 өдрийн А/247ийн захирамж 40,421.6 төгрөг, Тоглонгоо суралцъя А/106 гэрээний төлбөр 23,092.0 төгрөг, Боловсролын ерөнхий газрын даргын А/342, А/353, А/366, А/308, А/192, 60,802.0 төгрөг, Боловсролын үнэлгээний төвийн А/88 тушаалаар 2,277.0 төгрөг, тус бүр зориулалтын дагуу зарцуулж ажилласан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

"Шинэ багш" хөтөлбөрийн хүрээнд 4 зорилтын 22 арга хэмжээг хэрэгжүүлж, "Сургуульд суурилсан менежментийн загвар"-ыг хэрэгжүүлэн зорилтот 4 модулийн 223 төрлийн цахим болон танхимын сургалт, уулзалтад давхардсан тоогоор 52,284 багш, удирдах ажилтныг хамруулан 114.4 сая төгрөгийг зарцууллаа.

Тухайлбал: "Багш солилцоо" хөтөлбөрөөр 10 байгууллагын 16 хүн арга зүй, туршлагаа солилцож, 195 судалгаат хичээлийг зохион байгуулсан. Багшлах хүний нөөц, нөхөн хангалтыг сайжруулахаар "БАТЛАМЖ" шалгалтыг зохион байгуулж багш нарын ахиц, амжилтын судалгаа өмнөх оноос 4.0 хувиар ахисан ба 68.0 хувь нь 3-6 дугаар түвшний мэдлэгтэй байна.

Судлагдахуун тус бүрийн мэргэжил дээшлүүлэх сургалтуудад 19 чиглэлээр 2,272 багш, удирдах ажилтныг хамруулж ажилласан. Хөтөлбөрийн хүрээнд нийт багш нарын 80.0 хувь нь "Багш хөгжлийн төлөвлөгөө"-тэй ажиллаж, "Зөвлөх" зэрэгтэй багш 3-аар нэмэгдэн 12 болж, өмнөх оноос 38.0 хувиар, "Тэргүүлэх" зэрэгтэй багш 125 буюу 52.0 хувиар, магистр зэрэгтэй багш 74 буюу 9.2 хувиар тус тус өссөн байна. Үүний үр дүнд улсын илтгэлийн уралдаанд 6 дугаар байр, Нийгмийн тухай мэдлэгийн улсын эсээ бичлэгийн уралдаанд тэргүүн байр эзэлж, улсын төрөлжсөн олимпиадаас 3, 6, 13 дугаар байранд шалгарсан амжилт үзүүлээд байна. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөний хэрэгжилт 2022 оны жилийн эцсийн байдлаар 84.5 хувьтай байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Боловсрол Шинжлэх ухааны газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулахтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Булган аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор З.Ганбаатар гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Ж.Энхцоодол, газрын захирал, тэргүүлэх аудитор Б.Эрдэнэ нар тус тус хэрэгжүүлсэн.

Боловсрол Шинжлэх ухааны газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Булган аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 25-ний өдрийн 01/21 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2022 оны санхүүжилтийн дүнг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны санхүүжилтийн дүнгийн 3,510,738.8 мянган төгрөгөөс 75 хувиар буюу 39,495.8 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын гүйцэтгэлийн шатанд дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор тус байгууллага нь Өөрийн байгууллагын тээврийн хэрэгсэлд бүртгэлтэй УАЗ пургон БУА 19-20 улсын дугаартай автомашиныг төрийн хэмнэлтийн хуулийн дагуу Аймгийн ИТХ-ын 2022 оны XII дугаар хуралдааны актлуулах шийдвэр гаргуулсан.

Аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн хүрээнд 2022 онд нийт 171 мэдээ мэдээлэхээс хуулийн хугацаанд 171 мэдээг бүрэн мэдээлж, хугацаа хоцорсон мэдээ байхгүй байна.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тайлант онд албан хаагчдын албан томилолтоор ажилдах хугацаанд цалинг бодохдоо томилолтоор явсан хугацааны хоолны мөнгийг давхар тооцон 495,000.0 төгрөгийг илүү олгосон байна.дотоод хяналттай холбоотой зөрчил илэрлээ.

Шийдвэрлэсэн нь:

Төлбөрийн акт тогтоон шийдвэрлэв.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай /бусад хууль тогтоомжийн хүрээнд шалгасан зүйлийг холбогдох шалгуурт нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудит хийгдээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

2022 оны 06 дүгээр сарын 25-ны өдрийн 1/176 тоот албан бичгээр акт, зөвлөмжийн хэрэгжилтийн биелэлтийг хүргүүлсэн байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	0		0		100
Албан шаардлага	0	0	0	0	0
Зөвлөмж	4	6,856.2	4	0	100
Нийт дүн	4		4		100

Хэрэгжээгүй төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмж байхгүй болно.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Үндсэн хөрөнгө болон бараа материалыг хагас болон жилийн эцсийн тооллогоор тооцоо бодсон акт үйлдэж ажилласан эсэх.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 5,444.6 мянган төгрөгийн 5 зөрчил илэрснээс 1,666.3 мянган төгрөгийн 3 төлбөрийн акт, алдааг дахин давтан гаргахгүй байх 2 зөвлөмж өглөө.

5.1 Төлбөрийн акт

1. Тайлант онд гэрээний дагуу 10,741,675.0 төгрөгийн шатахууны худалдан авалт хийж 3 хувийн шатахууны буцаан авалт болох 322,250.25 төгрөгийн шатахууныг нярвын тайланд тусгаагүй анхан шатны баримтын бүрдэлгүй зарцуулсан байна.

2. Тайлант онд амралтын байрны түрээсийн орлогоос 800,000.0 төгрөгийн орлогыг бүрэн төвлөрүүлээгүй байна.

3. Албан хаагчдын цалинг бодохдоо томилолтоор явсан хугацааны хоолны мөнгийг давхар тооцон 544,000.0 төгрөгийг илүү олгосон байна.

5.2 Албан шаардлага

Албан шаардлага бичигдээгүй болно.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Үндсэн хөрөнгө, бараа материалын тооллоготой холбоотой асуудал

Илрүүлэлт:

Ерөнхий нягтлан бодогч нь үндсэн хөрөнгө, бараа материалын хагас жил болон жилийн эцсийн тооллогод тооцоо бодсон акт үйлдээгүй. Энэ нь Сангийн сайдын 2017 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн 345 дугаар тушаалаар баталсан маягт, зааврын дагуу гүйцтээгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Үндсэн хөрөнгө болон бараа материалыг хагас болон жилийн эцсийн тооллогоор тооцоо бодсон акт үйлдэж ажиллах.

2. Нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Анхан шатны баримтын иж бүрдэл дутуу 3,778.3 мянган төгрөгийн е баримтгүй гүйлгээ хийгдсэн байна. Энэ нь Татварын ерөнхий хуулийн 28.5-д заасан дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримтаар баталгаажсан байх, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” гэж заалттай нийцэхгүй байна

Өгсөн зөвлөмж:

Анхан шатны баримтыг хууль, дүрмийн дагуу иж бүрэн баримтаар гүйлгээг хийж хэвших.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2023 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
БШУГ	5	5,444.6	3	1,666.3	0	0	2	3,778.3	0	0	0	0
Дүн	5	5,444.6	3	1,666.3	0	0	2	3,778.3	0	0	0	0



БУЛГАН АЙМГИЙН
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
ТӨЛБӨРИЙН АКТ

2023 оны 02 дугаар сарын 24

Дугаар 02/03
10670250
ДНА-2023/183/на-СТА-ТШЗ

Булган сум

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Булган аймгийн Боловсрол, шинжлэх ухааны газрын 2022 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант онд амралтын байрны түрээсийн орлогоос 800,000.0 (найман зуун мянга) төгрөгийг бүрэн төвлөрүүлээгүй нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1-д "төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах", 16.5.2-т "батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-т "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно" гэж заасныг зөрчсөн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-д "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно." Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.3.5-д "бүртгэл тооцоог зөрүүтэй тооцоолсноос үр дагавар үүссэн" гэж заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Түрээсийн орлого дутуу төвлөрүүлсэн 800,000.0 (найман зуун мянга) төгрөгийг Булган аймаг дахь Төрийн аудитын газрын Төрийн сан банкин дахь аймгийн төсвийн орлогын 100040051005 тоот дансанд төвлөрүүлэх;

2. Актын биелэлтийг 2023 оны 05 дугаар сарын 25-ны дотор Булган аймаг дахь Төрийн аудитын газарт хариу ирүүлэхийг аймгийн Боловсрол, шинжлэх ухааны газрын дарга Ж.Ганболд, нягтлан бодогч Н.Хүрэлсүх нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

ДАРГА
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АУДИТОР



Б.ЭРДЭНЭ
Ж.ЭНХЦООДОЛ
З.ГАНБААТАР

006050292



БУЛГАН АЙМГИЙН
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
ТӨЛБӨРИЙН АКТ

2023 оны 05 дугаар сарын 24

Дугаар 05/АМ
10670/250
БИА-2023/1881-110-СГА-ТӨА

Булган сум

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Булган аймгийн Боловсрол, шинжлэх ухааны газрын 2022 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Албан хаагчдад албан томилолтын хугацаанд мөнгө 544,000.0 (таван зуун дөчин дөрвөн мянган) төгрөгийг хоолны мөнгө давхардуулж олгосон нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1-д "төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах", 16.5.2-т "батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-т "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно" гэж заасныг зөрчсөн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-д "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно." Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.3.5-д "бүртгэл тооцоог зөрүүтэй тооцоолсноос үр дагавар үүссэн" гэж заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Давхардуулан олгосон хоолны мөнгө 544,000.0 (таван зуун дөчин дөрвөн мянган) төгрөгийг Булган аймаг дахь Төрийн аудитын газрын Төрийн сан банкин дахь аймгийн төсвийн орлогын 100040051005 тоот дансанд төвлөрүүлэх;

2. Актын биелэлтийг 2023 оны 05 дугаар сарын 25-ны дотор Булган аймаг дахь Төрийн аудитын газарт хариу ирүүлэхийг аймгийн Боловсрол, шинжлэх ухааны газрын дарга Ж.Ганболд, нягтлан бодогч Н.Хүрэлсүх нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АУДИТОР

Б.ЭРДЭНЭ
Ж.ЭНХЦООДОЛ
З.ГАНБААТАР



006050382



БУЛГАН АЙМГИЙН
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
ТӨЛБӨРИЙН АКТ

2022 оны 02 дугаар сарын 24

Дугаар 01/02
А0670250
ДНА-2022/103/НА-СГА-ТШЗ

Булган сум

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Булган аймгийн Боловсрол, шинжлэх ухааны газрын 2022 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант онд гэрээний дагуу 10,741,675.0 (арван сая долоон зуун дөчин нэг мянга зургаан зуун далан таван) төгрөгийн шатахууны худалдан авалт хийсний 3 хувийн шатахууны буцаан авалт болох 322,250.0 (гурван зуун хорин хоёр мянга хоёр зуун тавин) төгрөгийн шатахууныг нярвын тайланд тусгаагүй анхан шатны баримтын бүрдэлгүй зарцуулсан байна.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1, 13.6, 13.7, 14.4 дэх заалтыг тус тус зөрчсөн, санхүүгийн тайлангийн аудитын тохиолдсон байх, нийцсэн бөгөөд зохистой батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно." Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.3.5-д "бүртгэл тооцоог зөрүүтэй тооцоолсноос үр дагавар үүссэн" гэж заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Нярвын тайланд тусгаагүй зарцуулсан 322,250.0 (гурван зуун хорин хоёр мянга хоёр зуун тавин) төгрөгийг Булган аймаг дахь Төрийн аудитын газрын Төрийн сан банкин дахь аймгийн төсвийн орлогын 100040051005 тоот дансанд төвлөрүүлэх;

2.Актын биелэлтийг 2023 оны 05 дугаар сарын 25-ны дотор Булган аймаг дахь Төрийн аудитын газарт хариу ирүүлэхийг аймгийн Боловсрол, шинжлэх ухааны газрын дарга Ж.Ганболд, нягтлан бодогч Н.Хүрэлсүх нарт хариуцуулав.

АКТ ТОГТООСОН:

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АУДИТОР

Б.ЭРДЭНЭ
Ж.ЭНХЦООДОЛ
З.ГАНБААТАР



006050384